

Боловсролын салбарын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Амгалан Мөнх-Эрдэнэ

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, санал өгөх, хэрэгжилтийг хангуулахад мэргэжил арга зүйгээр хангах							
1	Боловсролын хууль тогтоомж, дүрэм журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэх мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, түүний дотуур байрны үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж батлуулах	Хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна.	2	-	Боловсролын багц хууль шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг шинэчлэн	3-р сар, 4-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					боловсруулж, Мэргэжлийн болон техникийн боловсролын газар, нийслэл, орон нутгийн улсын байцаагчдаас санал авч, БШУ-ны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/150 дугаар тушаалаар батлуулсан. Хяналтын хуудсыг Боловсролын яамны цахим хуудсанд байршуулж, аж ахуйн нэгж, байгууллага татан авч өөрсдийгөө үнэлэх боломжтой ил тод болгосон. Хавсралт: 3 файл		
1.2. Иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх							
2	Эрсдэлийн үнэлгээ, хяналтын хуудасны бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, хяналт шалгалт хэрэгжүүлэх доод шатны нэгж, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллана.	Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн баяжуулалт (тоо) Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо Хамрагдсан улсын байцаагчийн тоо	Мэдээллийн сан - 0 Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн - 5 Хамрагдсан улсын байцаагч - 60	Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан хөтөлсөн байна. Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - 6 Хамрагдсан улсын байцаагч - 70	- Шилэн хяналтын мэдээллийн систем шинэчлэгдсэнтэй холбогдуулан яам, нийслэл, орон нутгийн улсын байцаагчдад шинээр эрх үүсгэн, боловсролын сургалтын байгууллагуудыг үнэлэх эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, хяналтын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа

					хуудсуудыг шинээр оруулсан. Сургууль, цэцэрлэгийн нэршилийг шинэчлэн бүртгэж оруулсан. Энэхүү шилэн хяналтын цахим системд хяналт шалгалтын мэдээллийг бүртгэх, боловсролын сургалтын байгууллагуудын эрсдэлийн үнэлгээг хийх талаар нийслэл, орон нутгийн улсын байцаагч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавин ажиллалаа. Мөн улсын байцаагчдын 2024 онд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын мэдээлэл, эрсдэлийн үнэлгээг байгууллага бүрээр үнэлж оруулж байгаад хяналт тавин баталгаажуулсан. 2024 онд Сургуулийн өмнөх боловсролын 1309 байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийснээс 368 нь бага, 770 нь дунд, 171 нь их эрсдэлтэй үнэлэгдсэн байна. Ерөнхий боловсролын 836 сургуульд эрсдэлийн	гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	---	--------------------------

					үнэлгээ хийснээс 154 нь бага, 558 нь дунд, 124 нь их эрсдэлтэй үнэлэгдсэн. - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 342 боловсролын байгууллагыг Шилэн хяналтын цахим системд объект бүрээр нэгбүрчилэн тулгалт хийж хянан, системд баталгаажуулах ажлыг хийж байна. Хавсралт: 4 файл		
3	Боловсролын багц хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох санал өгнө.	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 4	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 2	- Боловсролын багц хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан мэргэжлийн болон техникийн боловсролын чиглэлээр шинээр гарч буй 3 төрлийн дүрэм, журамд санал өгсөн. Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн

					боловсролын сургалтын байгууллагын орон тооны жишиг хязгаарын норматив, түүнийг хэрэгжүүлэх зааврын төсөлд санал өгсөн. - Боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүйн дүрэм шинээр батлагдах гэж байгаатай холбогдуулан уг дүрмийн төсөлд санал өгсөн. - Боловсролын багц хууль шинэчлэгдэн холбогдох дүрэм журам, шинээр болон шинэчлэн батлагдсантай холбогдуулан Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг	байдал: 100%
--	--	--	--	--	---	--------------

					шинэчлэн боловсруулж, нийслэл, орон нутгийн улсын байцаагчдаас санал авч, БШУ-ны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/150 дугаар тушаалаар батлуулсан.		
4	Их буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх, мэргэжил арга зүйгээр хангах	Шалгалт хийсэн объектын тоо 16 Зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин	Шалгалт хийсэн объектын тоо - 16 Зөрчил арилгуулалтын хувь - 55% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 64%	Шалгалт хийсэн объектын тоо - 11 Зөрчил арилгуулалтын хувь - 60% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 65%	- МУ-ын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/15 дугаар тушаалд тусгагдсаны дагуу Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 03-00/03 дугаар удирдамжаар 2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургуулиудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтад Монгол Солонгосын Политехник коллеж, "Универсал" политехник коллеж, Өвөрхангай аймаг дахь Политехник коллеж, Баянхонгор	4-р сар, 6-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					аймаг дахь "Өлзийт" мэргэжлийн боловсролын сургууль хамрагдлаа. Шалгалтаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/150 дугаар тушаалаар батлагдсан 03/6.1-3 кодтой Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, 03/6.1-4 кодтой Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, 03/6.1-6 кодтой Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсаар үнэлж, Монгол Солонгосын политехник коллеж, Өвөрхангай аймаг дахь Политехник коллеж 16,9% буюу бага эрсдэлтэй,		
--	--	--	--	--	---	--	--

					"Универсал" политехник коллеж дунд эрсдэлтэй, Баянхонгор аймаг дахь "Өлзийт" мэргэжлийн боловсролын сургууль 61,5% буюу их эрсдэлтэй үнэлэгдлээ. Илэрсэн зөрчилтэй холбогдуулан 2 байгууллагад улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Шалгалтаар дадлагын газар нь шаардлагатай тоног төхөөрөмж дутмаг, дадлагын газарт багшийн өрөө, суралцагчийн хувцас солих орчинг бүрдүүлээгүй, суралцагчдыг мэдээллийн цахим санд үнэн зөв бүртгэдэггүй, эрэлттэй мэргэжлийн хөтөлбөр нь магадлан итгэмжлэгдээгүй, дотоод хяналт хангалтгүй зэрэг зөрчил дутагдал илэрсэн. Илэрсэн зөрчилтэй холбогдуулан улсын ахлах байцаагчийн		
--	--	--	--	--	---	--	--

					албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Мөн орон нутагт тухайн аймгийн улсын байцаагч нар 6 мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад хяналт шалгалт хийсэн. Хавсралт: 3 файл		
5	Хэнтий аймгийн Боловсролын газар болон их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийх	Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо Зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин	-	-	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 05 дугаар сарын 15-ны 03-00/20 дугаар удирдамжийн дагуу ажлын хэсэгт орж ажиллан, Хэнтий аймгийн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ.	4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Шалгалтад Хэнтий аймгийн Өндөрхаан сумын 8-р цэцэрлэг, 5-р сургууль, политехник коллеж, Норовлин, Дадал, Баян-Адарга сумын цэцэрлэг, сургуулиуд хамрагдан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, Дадал сумын цэцэрлэгт улсын ахлах байцаагчдын 11 заалт бүхий албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Хавсралт: 3 файл		
6	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолын дагуу зохион байгуулалтын өөрчлөлт орж нэгдсэн политехник коллежүүдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Хяналт шалгалт хийсэн объектын тоо Зөрчил арилгуулалтын хувь	-	Хяналт шалгалт хийсэн объектын тоо - 13 Зөрчил арилгуулалтын хувь - 50%	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 420 дугаар тогтоол, Боловсролын яамны Салбарын хяналтын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 03-00/32 дугаар бүхий “Монгол	9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Улсын Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолоор зохион байгуулалтын өөрчлөлт орсон болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/258, А/335 дугаар тушаалаар ангилал өөрчлөгдсөн политехник коллежуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамж"-аар Мэргэжлийн болон техникийн боловсролын газартай хамтран 3 байгууллагад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажиллах талаар үүрэг чиглэл өглөө. Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт орсон Архангай, Дархан, Хөвсгөл, Булган, Төв, Дорнод, Орхон, Сэлэнгэ, Өмнөговь аймгийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудад		
--	--	--	--	--	--	--	--

					аймаг дахь боловсролын хяналтын улсын байцаагч нар хяналт шалгалт хийсэн. Шалгалтын дүнг нэгтгэж байна. Хавсралт: 1 файл		
7	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь Зөрчил арилгуулалтын хувь	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 90% Зөрчил арилгуулалтын хувь - 95%	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 90% Зөрчил арилгуулалтын хувь - 70%	- МУ-ын Хүний эрхийн үндэсний комиссоос ирүүлсэн албан бичгийн дагуу Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан холбогдох дүрэм журмын хүрээнд Сүхбаатар дүүрэгт байрлах ерөнхий боловсролын “Шинэ үе” сургуульд суралцагч ялгаатай хэрэгцээнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдсан эсэх, хувь хүний хөгжил, сурч боловсрох хэрэгцээ шаардлагыг хангасан таатай орчин нөхцөл бүрдүүлсэн эсэхэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хийлээ. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан цаашид хүүхдийг үндэс, угсаа, хөгжлийн онцлог, эрүүл мэнд зэрэг ялгаатай хэрэгцээнээс үл хамааран элсэн суралцах нөхцөл боломжийг бүрдүүлэх, суралцсан тохиолдолд хуульд заасны дагуу тэгш боломжоор ханган суралцуулах талаар улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өглөө. Боловсролын сайдын 2024 оны А/127 дугаар тушаал, Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 03-00/36 дугаар удирдамжийн дагуу Салбарын хяналтын газрын шинжээч, улсын ахлах байцаагч, БЕГ-ын Ерөнхий боловсролын салбарын статистик, тоон мэдээлэл хариуцсан		
--	--	--	--	--	--	--	--

					мэргэжилтэн, Булган аймгийн Боловсролын газрын улсын ахлах байцаагч, статистик, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан арга зүйч нартай хамтран Булган аймгийн Булган сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуульд иргэний гомдлын дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын ахлах байцаагчдын 03-00-006/20 дугаартай хамтарсан албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, зөрчилтэй холбогдуулан 2 хариуцсан албан тушаалтанд Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авлаа. Хяналт шалгалтаар хуурамчаар үйлдсэн боловсролын баримт бичигт улсын ахлах байцаагчдын 03-00-006/01 дугаартай акт үйлдэж, холбогдох хуулийн байгууллагад		
--	--	--	--	--	---	--	--

					шилжүүлсэн. Хавсралт: 3 файл		
8	Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх	Албан шаардлагын тоо Зөрчил арилгуулалтын хувь	Албан шаардлагын тоо - 5 Зөрчил арилгуулалтын хувь - 58%	Албан шаардлагын тоо - 4 Зөрчил арилгуулалтын хувь - 60%	Монгол Улсын их хурлын чуулган дээр Н.Алтанхуяг гишүүний тавьсан асуудлын дагуу нийслэлийн ерөнхий боловсролын "Өнөр" сургуульд хийсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар илэрсэн зөрчилтэй холбогдуулан улсын ахлах байцаагчдын хамтарсан албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Албан шаардлагын биелэлтийг хангасан эсэхэд үнэлэлт өгөхөөр тус сургуульд Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 03-00/39 дүгээр удирдамжийг боловсруулж, батлуулсан. Удирдамжийн дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч, санхүүгийн хяналт шалгалтын	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					улсын ахлах байцаагч О.Баярсүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч М.Ууганбаатар нартай хамтран гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн. Хавсралт: 1 файл		
3.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах							
9	Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг тайлагнах.	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо	2023 оны биелэлтийн хувь	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Салбарын хяналтын газарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг биелэлтийг нийт 12 удаа гаргаж, цахим системд хугацаанд нь тайлагнасан. Үүнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоол, 2023 оны 45 дугаар хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					албан даалгаврын холбогдох заалтын биелэлтийг гаргасан.		
10	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, сар бүр гүйцэтгэлийг тайлагнах	Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан, Хэрэгжилтийг тайлагнасан байна.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө - 1 Тайлагналт - 12	Тайлагналт - 12	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны 01 сард боловсруулж батлуулсан. Мөн яамны нэршил өөрчлөгдөж, бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж цахим системд оруулж батлуулсан. Төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайланг сар бүр гаргаж, төрийн мэдээллийн цахим системд тайлагнасан. Салбарын хяналтын газраас сард хийсэн томоохон ажлын тайланг нийт 12 удаа гаргаж системд илгээсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
11	Цаг үеийн нөхцөл шаардлагаар хийж хэрэгжүүлэх ажил үйлчилгээг гүйцэтгэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ Гүйцэтгэлийн хувь	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээ – 100 Гүйцэтгэлийн хувь - 100%	- Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 03-00/18 дугаар удирдамжийн дагуу 2 дугаар ажлын хэсгийг ахлан олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн

					ерөнхий боловсролын Сэлбэ, Шинэ үе, Гэгээ, Улаанбаатар элит, Орхон хасу, Жаргалан сургуулиудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг хэдий ч үндэсний хөтөлбөр хэрэгжүүлдэггүй, олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш дутагдалтай, удирдах зөвлөлгүй зэрэг зөрчил дутагдал илэрч, илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөрчлийг арилгах талаар анхааруулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. - БШУ-ны сайдын 2024 оны А/50 дугаар тушаалын дагуу дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэлт гаргах 1 дүгээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан, нийслэл, Эрдэнэт, Дархан, Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж	сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	---	-------------------------	---

					байгаа 39 их дээд сургуульд хяналт шалгалт хийж, сургууль бүрээр шалгалтын дүн, тоон үзүүлэлт, тайланг гаргасан. - Боловсролын сайдаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 03-00/38 дугаар удирдамжийн дагуу нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай ерөнхий боловсролын “Шинэ үе”, "Улаанбаатар", "Соёл эрдэм", “Эм Ай Ю”, Г.В.Плехановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургуулийн Улаанбаатар хотын салбар ерөнхий боловсролын сургуулиудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх багшийн хүрэлцээ хангамжид анхаарах,	
--	--	--	--	--	--	--

					мэргэжлийн, багшлах эрхтэй багшаар бүрэн хангагдах талаар үүрэг даалгавар өгсөн. - 2024 онд БШУ-ны яамны 100 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах дэд ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллан, арга хэмжээний хүрээнд хийх ажлын төлөвлөгөө, арга хэмжээний хөтөлбөр зэргийг боловсруулсан. Мөн зохион байгуулах газар, хамтран ажиллах байгуулах байгууллага, урлагийн арга хэмжээний зэрэг газруудтай уулзаж, гэрээг хийж, батлуулан, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Хавсралт: 3 файл		
12	Хяналт шалгалтын төлөвлөгөөний төсөл болон 2025 онд хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг гаргаж,	Хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.	1	Төлөвлөгөөний төслийг хүргүүлсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолын 3.4-т заасны дагуу боловсролын	10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх				сургалтын байгууллагуудын 2024 оны эрсдэлийн үнэлгээг нийслэл, орон нутгийн улсын байцаагчид Засгийн газрын 2024 оны 195 дугаар тогтоолоор батлагдсан эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлэн, Шилэн хяналтын цахим системд бүртгэн, эрсдэлийн үнэлгээг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 355 боловсролын сургалтын байгууллагуудад 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн. Боловсролын салбарын хяналтын газраас 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний төсөл, мөн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 335 боловсролын сургалтын байгууллагыг 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулахаар саналыг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 11/1849 тоот албан бичгээр Хяналт,	үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--	--

					үнэлгээний үндэсний хороонд хүргүүлсэн. Хавсралт: 1 файл		
3.2. Төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх							
13	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, тайланг сар бүр гаргах	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан, Хэрэгжилтийг тайлагнасан байна.	10	6	Төрийн албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Мөн ямны нэршил өөрчлөгдөн, бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн цахим системд оруулж, батлуулсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар бүр, хагас бүтэн жилээр гаргаж тайлагнан, төрийн мэдээллийн цахим системд тухай бүр оруулсан.	1-р сар, 2- р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
14	Холбогдох хуульд заасан журмын дагуу ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих байгууллагад мэдүүлэх	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг мэдүүлж баталгаажуулсан байна.	1	-	Хууль тогтоомжид заасны дагуу төрийн албан хаагчийн хөрөнгө оруулгын мэдүүлгийг гаргаж, 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Хүний нөөцийн мэргэжилтэнд	1-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын

					хүлээлгэн өгсөн. Хавсралт: 1 файл		үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах							
15	Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын мэдээлэл, хяналтын хуудсыг олон нийтэд нээлттэй байршуулах, хяналт шалгалтын талаарх шаардлагатай мэдээллийг ил тод болгох	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь	2023 оны байршсан мэдээлэл	Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл байршсан байна.	- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын мэдээлэл, шинэчлэн батлагдсан хяналтын хуудасны мэдээллийг байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулсан. Мөн шалгалтад хамрагдсан байгууллагын шалгалтын мэдээлэл, хяналтын хуудасны мэдээллийг Шилэн хяналтын цахим системд оруулсан. - Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, Мэргэжлийн болон	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, батлуулан, Боловсролын яамны цахим хуудсанд байршуулж, аж ахуйн нэгж, байгууллага татан авч өөрсдийгөө үнэлэх боломжтой болгосон. - Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллага тус бүрээр тоон үзүүлэлтийн графикийг гарган 2023-2024 оны боловсрол, шинжлэх ухааны салбарын статистик мэдээллийн номонд оруулсан.		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны болон салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн шинээр болон шинэчлэн батлагдсан дүрэм журмыг уншиж судлах	Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг тухай бүр уншиж, судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.	Хууль эрх зүйн мэдлэг сайжирсан.	Албан хаагчийн хууль эрх зүйн мэдлэг сайжирсан байна.	Боловсролын багц хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан шинээр гарч буй дүрэм журмыг уншин судалж, хяналт шалгалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Мөн мэргэжлийн болон техникийн боловсролын чиглэлээр 16 шинэ, шинэчлэгдэн батлагдсан журмын бүртгэлийг хийн, нийслэл, орон нутгийн улсын байцаагчдад мэдээллийн сан үүсгэсэн. - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г уншиж судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%
2	Мэргэжил, боловсролоо	Яам болон холбогдох	ТАХ-ын танхимын	Албан хаагчийн	- БНСУ-ын Дэжон хотод 2024 оны 06 дугаар сарын 11-ний	1-р сар, 2-р сар, 3-р сар,	Өөрийн

	дээшлүүлэх чиглэлээр танхимын болон цахим сургалтуудад хамрагдана.	газруудаас зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад хамрагдана.	болон цахим сургалтад хамрагдсан.	мэргэжлийн ур чадвар дээшилсэн байна.	өдрөөс 19-ний өдрүүдэд зохион байгуулсан "Дижитал боловсролын хүрээнд туршлага судлах" сургалтад хамрагдаж, амжилттай суралцан сертификат авсан. - ЦХХХЯ-наас 3 удаа зохион байгуулсан "Эрсдэлийн шалгуур үзүүлэлт, хяналтын хуудас угсрах" сургалт, "Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн хөтлөх, ашиглах, мэдээлэл оруулах талаар сургалтуудад, ТА3, ТЗУГ-аас зохион байгуулсан дараах сургалтуудад тухай бүр оролцсон. - ТА3-өөс төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, манлайллыг дэмжих ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх "7:4:10" сургалтад хамрагдаж, "Төрийн албан хаагчийн ёс зүй ба Эрүүл мэнд" сэдвээр Ёс зүйн хорооны гишүүн, доктор М.Цэрэнбатыг хийсэн мэдээллийг хүлээн авч, ёс зүйн мэдлэгээ дээшлүүлсэн. - ТУЗГ-аас зохион байгуулсан "Хөгжил ба мэдлэг" сэдэвт сургалтад хамрагдаж, Датаком компаний үүсгэн байгуулагч, энтрепренер, Ph доктор Д.Энхбатын сонирхолтой лекцийг сонсож, мэдээлэл авсан. - Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан МУ-ын Ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр захирамжаар	4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
--	--	---	-----------------------------------	---------------------------------------	--	---	---

					батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2024-2027”-г танилцуулах сургалтад хамрагдсан. - ТАЗ-өөс зохион байгуулсан "7:4:10" сургалтад хамрагдаж, төрийн албаны зөвлөлийн захиалгаар хийгдэж буй "ТАХ-ийн сэтгэл ханамж, түүнд нөлөөлж буй хүчин зүйл" судалгааны зорилго, явцын талаар мэдээлэл авсан. Мэдээллийг судалгааны багийн ахлагч, ШУА-ийн Философийн хүрээлэнгийн социологийн салбарын эрдэм шинжилгээний дэд ажилтан, доктор О.Баасантогтох танилцуулж, мэдээлэл өгсөн. - "Витамины хэрэглээ" болон багц оношилгооны талаар товч мэдээлэл - Нурагийн ерөнхий эмч С.Цэрэнпагма, - "Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал" сэдвээр ХАБ, эрүүл мэндийн төвийн ХАБЭА-н сургалт хариуцсан мэргэжилтэн Х.Дарьсүрэн, - "Ажилтны сэтгэл зүйн эрүүл мэндийн үндэс, стресс" зэрэг сэдвүүдээр мэдээлэл сонсож, мэдлэгээ дээшлүүлсэн.		
--	--	--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Боловсролын салбарын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Амгалан Мөнх-Эрдэнэ /...../
.....

Огноо: